

# ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТҮҮХЧИДСЭН ДАВДАХ



## БАЙГУУЛЛАГЫН НЭР БОЛОН ХАРЪЯАЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ

Д/д	Шийдвэрийн огноо	Шийдвэрийн дугаар	Нэрийн өөрчлөлт	Оны хязгаар
1.	1962	БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 88 дугаар зарлиг	Ардын депутатуудын гүйцэтгэх захиргаа	1962-1997 он
2.	1997	Монгол Улсын шинэ Үндсэн хууль	Нийслэлийн Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар	1997 оноос одоог хүртэл

### БАЙГУУЛЛАГА ҮҮСЭХ БОЛСОН ТҮҮХЭН НӨХЦӨЛ:

Түшээт хан аймгийн Дархан Чин Вангийн хошуу Пунцагцэрэн гэгч ноёны хамжлагын албат нутаглаж байсан Богд хан уулын зүүн, Баянзүрх хайрханы зүүн урд талын хойноосоо налуу хөтлийг Налуугийн ухаа гэдэг байсан. Энэ налуу хөтөл бэлчээр сайтай, тарвага зурам ихтэй, адуу мал багширсан, аянчин тарвагачны хөл хөдөлгөөн тасардаггүй нутаг байсан бөгөөд тарваганы ухсан нүхнээс хар алт гарсан цагаас Налайхын түүх эхэлдэг.

Ардын хувьсгал ялсны дараа буюу 1922 оны 12 дугаар сарын 25-ны өдөр засаг төрөөс Налайхын чулуун нүүрсний ордыг улсын мэдэлд авч ашиглах ажлыг эхлүүлсэн ба тухайн үед 12 ажилчин жилдээ 871 тонн нүүрс олборлодог байсан түүхтэй. Улмаар 1932 оны намар уурхай улирлын чанартай, гар ажиллагаатай байсныг өөрчилж 60 квт-ын хүчин чадалтай Германы Локомовиль маркийн станц тавьж гэрэлтүүлэгтэй болж, шинэ 1, 2-р уурхайг ашиглаж, 3-р уурхайг нээсэн гэдэг. Энэ үед нүүрс гаргалт нь 20050 тонн болж, 1922 оныхоос 23 дахин өсөж байсан гэдэг. Налайхын уурхай улсын үйлдвэр болж, Монгол улсын аж үйлдвэрийн тулгын чулууг тавилцан Нийслэлийг дангаараа 80 гаруй жил илч дулаанаар хангаж ирсэн түүхтэй. Энэхүү нүүрсний ордыг түшиглэн байгуулагдсан Налайх суурин 1924 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн заалтын дагуу Амгаланбаатар хотын 7 дугаар хороонд харьяалагдаж, захиргааны үүргийг уурхайн дарга нар хавсран гүйцэтгэж байжээ.

Налайх дүүрэг нь Нийслэлийн Баянзүрх дүүрэг, Төв аймгийн Сэргэлэн, Эрдэнэ сумтай хил залган Монгол орны ойт хээрийн бүсэд 68,7 мянган га нутаг дэвсгэрийг хамардаг. Дүүргийн нийт нутаг дэвсгэрийн 40 гаруй хувь буюу 28 мянган га газар улсын тусгай хамгаалалтын газарт харьяалагддаг. Өнөөдрийн байдлаар 100 гаруй аж ахуйн нэгж, иргэд нүүрс, тоосго, шавар олборлох лиценз эзэмшиж байна. Түүнчлэн газар нутгийн 40 гаруй хувийг бэлчээр, газар тариалангийн зориулалттай газар нутаг эзэлж байна. Дүүргийн хэмжээнд Горхи Тэрэлжийн чиглэлд олон улсын зэрэглэлтэй 5 одтой-1, 2 одтой-1 гэсэн 2 зочид буудал, аялал жуулчлал зориулалттай 70 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.

Дүүргийн төв нь Улаанбаатар хотоос 36 км зайтай оршдог бөгөөд байгалийн үзэсгэлэнт түүхт дурсгалын газруудтай. Үүнд: Таньюкийн хөшөө, Чингисийн хөшөө, Хан хэнтийн дархан цаазат газар, Майхан уул, Гүнжийн сүм, Бүс нуур, Туул гол, Тэрэлж гол гэх мэт.

Жилээс жилд дүүргийн өнгө үзэмжийг сайжруулах, иргэдийн тав тухтай орчинд ажиллаж амьдрах нөхцлийг сайжруулахаар улс болон нийслэлийн хөрөнгө оруулалтаар томоохон ажлууд хийгдэж байна. Үүнд: Налайх-Тэрэлж, Агуйтын чиглэлийн автозамын шинэчлэлийн ажил, “Шинэ Налайх” цэцэрлэгт хүрээлэн, бүх хороонд нэг цэгийн үйлчилгээний цогцолбор барилга, мөн 7 хорооны нутаг дэвсгэрт амралт чөлөөт цагийн талбай, орчин үеийн шийдэл бүхий эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлгүүдийг шинээр хийж суурилуулан бүтээн байгуулалтын ажлуудыг хийгээд байна.

### **Налайхын төр захиргааны байгууллагын үүсэл хөгжил:**

1955 онд Улаанбаатар хотын “Уурхайчдын хороо захиргаа” болон зохион байгуулагдаж хороо захиргааны даргаар Б.Сосор, Ёндон, нарийн бичгийн даргаар Ш.Лувсандамдин нарын хүмүүс ажиллаж байжээ.

Нүүрсний уурхайн өсөлт хөгжил, улс орныг аж үйлдвэржүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд оруулж байгаа жинтэй хувь нэмрийг харгалзан МАХН-ын Төв хорооны тогтоол гарч 1962 онд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 88 дугаар зарлигаар Нийслэлийн **Налайх хот** болгон зохион байгуулсан байна.

### **БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭЖ БАЙСАН ӨМНӨХ БАЙГУУЛЛАГЫН НЭР:**

#### **Ардын Депутатын Хурлын Гүйцэтгэх Захиргаа**

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1962 оны 88 дугаар зарлигаар Улаанбаатар хотын засаг захиргааны нэгж Уурхайчдын хороо захиргааг татан буулгаж Налайх хот, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1965 оны 4 дүгээр сарын 14-ний 79 дүгээр

зарлигаар Улаанбаатар хотыг Ажилчин, Найрамдал, Октябрь, Сүхбаатарын район гэсэн засаг захиргааны 4 районд хуваагаад Налайхыг Улаанбаатар хотын харъяанд бие даасан хот хэвээр үлдээсэн байна. Харин сүүлд “Налайхын район” нэртэйгээр Улаанбаатар хотын 5 дахь район болсон.

### АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГААР АЖИЛЛАЖ БАЙСАН ХҮМҮҮС



Налайх хотын АДХГЗ-ын  
дарга Ч.Шэгдар  
1962-1979 он



Налайх районы АДХГЗ-ын  
дарга Ч.Цэдэнданба  
1979-  
1981 он



Налайх районы АДХГЗ-ын  
дарга А.Чансерхаан  
1981-  
1985 он



Налайх районы АДХГЗ-ын  
дарга Л.Жавзнаа  
1985-1987 он



Налайх районы АДХГЗ-ын  
дарга Н.Жалцаг  
1987-1990 он



Налайх районы АДХГЗ-ын  
дарга Н.Жалцаг  
1987-1990 он

1992 оны шинэ Үндсэн хуулиар “Монгол нутаг дэвсгэр, засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.” гэж заасны дагуу Нийслэлийн Налайх дүүрэг болон хөгжиж ирсэн түүхтэй.

Монгол Улсын 1992 оны шинэ Үндсэн хуулийн дагуу хуучин АДХ-ын Гүйцэтгэх захиргаа нь Засаг даргын Тамгын газар болж өөрчлөгдсөн.

Тус дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгууд нь 1998, 2001, 2005, 2008, 2013 онд тус тус нэрийн өөрчлөлт орж байсан байна. Үүнд:

1. 1998 оноос Төрийн захиргаа удирдлагын хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Төлөвлөлт санхүү, эдийн засгийн хэлтэс, Орон нутаг үйлчилгээний хэлтэс.
2. 2001 оноос Төрийн захиргаа удирдлагын хэлтэс, Санхүү, эдийн засгийн хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Тохижилт, үйлдвэр, үйлчилгээний хэлтэс
3. 2005 оноос Төрийн захиргааны хэлтэс, Санхүү, эдийн засаг, төрийн сангийн хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Үйлдвэрлэл, тохижилт, үйлчилгээний хэлтэс

4 2009 оноос Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийгмийн хэлтэс, Үйлдвэрлэл үйлчилгээний хэлтэс болж өөрчлөгдөж байсан.

5. Шинэчлэлийн Засгийн газрын 2012 оны 190 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2013 оны А/05 дугаар захирамжаар Захиргаа, хуулийн хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Төхижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс, Цэргийн штаб бүтэцтэйгээр төрийн болон орон нутгийн үйлчилгээ үзүүлж байна .

## НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГА



1992 оноос нутгийн өөрөө удирдах ёс Монгол улсын Үндсэн хуулиар баталгаажиж, орон нутагт Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Иргэдийн нийтийн хурлууд бий болсон. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 1992 оноос 1996 он хүртэл 2 жилийн хугацаатай, 1996 оноос 4 жилийн хугацаатайгаар сонгогддог болсон.

1996, 2000, 2004, 2008 онд явагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулиар 15 төлөөлөгчтэй, 5 Тэргүүлэгчтэй, Тэргүүлэгчдийн дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, Хурлын Ажлын албатай ажиллаж байлаа.



НАЛАЙХ ДҮҮРГИЙН ИТХ-ЫН ДАРГА  
А.ГАНБОЛД



НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА  
Х.БОЛДБААТАР

**НАЛАЙХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ДАРГААР АЖИЛЛАЖ БАЙСАН ХҮМҮҮС**



Т.Энхтайван  
1992-1993 он



Д.Орги  
1993-1994 он



Г.Чулуунбат  
1994-1996 он



Л.Дамдинсүрэн  
1996-2000 он



Д.Батдорж  
2000-2004 он



С.Батдорж  
2004-2012 он



Нийслэлийн Налайх дүүргийн иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид (2012-2016 он)

**ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРАЛД АЖИЛЛАЖ БАЙСАН  
БОЛОН ОДОО АЖИЛЛАЖ БАЙГАА ТӨЛӨӨЛӨГЧИД**

<b>1992-1994 он</b>	Б.Чойжилжав Н.Гэрэлсүрэн Т.Дашдэлэг Д.Чулуунбаатар Д.Цэнд Н.Энэбиш	<b>1994-1996 он</b>	Д.Нацаг В.Бадамцэцэг Б.Дондов С.Гонгор Д.Дулмаа Ж.Нэргүй Д.Батдорж Г.Чулуунбат Б.Баасансүрэн Ч.Батаа Я.Ичваан Ш.Ванганжил	<b>1996-2000 он</b>	Д.Батдорж Т.Энхтайван П.Чинбат Б.Оюунгэрэл Г.Чулуунбат	<b>2000-2004 он</b>	Д.Батдорж Ц.Дашдолгор Х.Сауле Н.Барамсай О.Ендонжамц Т.Энхтайван С.Отгонбаяр З.Болдбаатар Г.Чулуунбат М.Нэргүй	<b>2004-2008 он</b>	Н.Барамсай С.Батдорж Т.Энхтөр Д.Энхтуул Б.Оюунчимэг Ц.Минжинхүү Ш.Ванганжил Г.Баттөмөр Б.Баяндэлгэр Л.Дамдинсүрэн Энхцэцэг Д.Батдорж Ш.Энхсайхан	<b>2008-2012 он</b>	Н.Төлөв Н.Биелхаан О.Манарбек З.Батырбек Д.Энхтуул Л.Эрдэнэцэцэг Э.Хорлоо Б.Бямбасүрэн Ц.Гомбо Г.Баттөмөр З.Болдбаатар Ц.Дашдолгор С.Батдорж Ш.Энхсайхан Ч.Зоригт М.Өсөхбаяр М.Дашхүү Ч.Одонхүү М.Дамдинхүү Ч.Одонхүү	<b>2012 оноос</b>	А.Ганболд Д.Бадамсайхан Б.Эрдэнэбат Ч.Зоригт Ш.Хаан М.Өсөхбаяр М.Дашхүү Ч.Одонхүү К.Сейтхан Б.Мурат	<b>Р.Жанарбек</b> Л.Жаргалтулга А.Тулга П.Нарантуяа Б.Батболд С.Тунгалаг Т.Чулуунгэрэл Б.Лхагва-Очир Б.Нэргүй Т.Энхжаргал Х.Болдбаатар С.Нэргүй О.Ганболд Д.Цогоо Ц.Хатанбаатар
---------------------	---	---------------------	--	---------------------	--	---------------------	---	---------------------	--	---------------------	--	-------------------	--	---

**НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААР АЖИЛЛАЖ БАЙСАН ХҮМҮҮС**



Налайх дүүргийн Засаг дарга Ч.Жигжидсүрэн  
1992-1997 он



Налайх дүүргийн Засаг дарга Б.Энхбаяр  
1997-1998 он



### **НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧООР ТОМИЛОГДОН АЖИЛЛАЖ БАЙСАН ХҮМҮҮС:**

Н.Дондогдорж, Ц.Дашдэндэв, Т.Эрдэнэчимэг, Д.Наянтай, Б.Шугарсүрэн, Я.Дэчмаа, Д.Загдзэсэм /1990-1992/, Л.Дамдинсүрэн /1992-1996/, П.Чинбат /1996-2000/ , Б.Баяндэлгэр /2000-2003/, Д.Цэнд /2003-2004/ Ц.Минжинхүү /2004-2008/, З.Болдбаатар 2008-2012/, Д.Цогоо, Ч.Одонхүү, Т.Чулуунгэрэл /2012 оноос/

### **НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**



**Эрхэм зорилго:** Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргыг мэргэжлийн өндөр түвшний зөвлөгөө, цаг үеэ олсон хэрэгцээт мэдээллээр хангаж, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан, иргэдэд нээлттэй, хүртээмжтэй, чин шудрага үйлчлэхэд оршино.

Засаг даргын Тамгын газар нь дүүргийн Засаг даргын үйл ажиллааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, нийгэм эдийн засгийн зорилтыг хангах, Тамгын газрын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, удирдлагын манлайлалыг дээшлүүлэх, төр засаг, нийслэлийн удирдлагын тогтоол, шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих нутгийн захиргааны удирдлага зохицуулалтаар хангах, боловсон хүчний мэдлэг боловсрол, мэргэшлийг дээшлүүлэх, хэлтэс албад, хамтын ажиллагааг хангах, удирдлагыг хэрэгжүүлэх үндсэн зорилтын хүрээнд иргэдэд төр, нийгмийн үйлчилгээг үзүүлэх, үйл ажиллагаагаа явуулна.



**Цаашдын зорилт:** Ажлын гүйцэтгэлтэй уялдсан урамшууллын илүү тод дүрэм журмыг дотооддоо боловсруулан хүний нөөцийн дэвшилттэй арга нэвтрүүлснээр ажилтнуудын ажил, үүрэг гүйцэтгэх арга барил, чадварт өөрчлөлт оруулах:

- ✓ Төрийн албаны тусгайлсан сургалт нь ажилтнуудын мэдлэг, ур чадварын түвшинг дээшлүүлж, төрийн албаны мэргэшсэн байдлыг сайжруулж, гүйцэтгэлийн өндөр түвшинг хангах болно:
- ✓ Боловсон хүчний талаархи шийдвэрийг улам ил тод болгох:
- ✓ Төрийн албыг улс төрөөс ангид байлгахын төлөө ажиллах:
- ✓ Нутгийн удирдлага, нутгийн албыг бэхжүүлэн, төвлөрүүлэх талаар төрийн албан хаагчид болон иргэд олон нийтийн ойлголтыг төлөвшүүлэх:



Дүүргийн Засаг даргын Тамгын газар нь 5 хэлтэс, 1 тасагтайгаар иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэж, иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэх, дүүргийн хөгжил дэвшил, сайн сайханы төлөө хувь нэмэрээ оруулан ажиллаж байгаа ба Засаг даргын Тамгын газрын даргаар Орногбайн Манарбек ажиллаж байна.



Захиргаа, хуулийн хэлтсийн даргаар Лхамцэрэнгийн Болормаа



Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргаар Пүрэвжавын Цэнд-Аюуш



Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга  
Адилбишийн Туяабаатар



Нийгмийн хөгжлийн хэлтсийн даргаар Батаагийн Эрдэнэцогт



Цэргийн штабын даргаар хурандаа Даваанямын Байгал нар ажиллаж  
байна.

Нийслэлийн Налайх дүүрэг одоо засаг захиргааны үндсэн нэгж 7 хороотой. Хороод нь анх Хорооны Засаг дарга, зохион байгуулагч гэсэн хоёрхон орон тоотой байсан бол одоо 5-7 орон тооны ажилтантай болж эрх хэмжээ, бүтэц, зохион байгуулалтын хувьд бэхэжсээр байна.

## НЭГДҮГЭЭР ХОРОО



Хорооны Засаг дарга  
Н. Амгалан

1 дүгээр хороо нь одоогийн хуучин барилгыг 1962-1963 онд дарга Сэнгэдорж иргэдийнхээ, тулгуурлан барьж байгуулжээ.

1975-1976 онд Хорооны конторын барилгыг кино театрын дэргэд барьж, районы АДХ-ын Гүйцэтгэх захиргааны шийдвэрээр Хорооны даргаар орон тооны хүн ажиллах болжээ. 1992 оноос “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуульд зааснаар “нийслэлийн

Налайх дүүргийн нэгдүгээр хороо” хэмээн нэрлэгдэх болж Засаг даргаар М.Халзан ажиллаж байжээ. Одоо хорооны Засаг даргаар Н.Амгалан ажиллаж байна.



Нутаг дэвсгэрийн хэмжээ: 6086 га,

Өрх: 1483,

Хүн амын тоо: 5646

Малын тоо толгой: 9094

1 дүгээр хорооны Засаг даргаар ажиллаж байсан хүмүүс:

1962-1963 онд Н.Сэнгэдорж

2000-2001 онд Д.Цэрэн

1963-1979 онд Пүрэвжав  
1979-1982 онд Д.Гирдгаабазар  
1982-1993 онд М.Халзан  
1993-2000 онд С.Гонгор

2001-2004 онд П.Сашка  
2004-2009 онд Н.Дамдинсүрэн  
2009-2010 онд С.Тунгалаг  
2010-2012 онд Х.Баярсайхан  
2012 оноос Н.Амгалан

## ХОЁРДУГААР ХОРОО



Налайх 1955 онд Улаанбаатар хотын засаг захиргааны “Уурхайчдын хороо захиргаа” болоход уурхайчдын болон тэдэнд зориулсан үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч нэгжид ажиллагч хөдөлмөрчид, тэдний ар гэрийнхэнд үйлчлэх зорилгоор Хорин нэртэйгээр байгуулагдсан анхны хорооны нэг юм. Хорооны Засаг даргаар Ж.Нямсүрэн ажиллаж байна.



Нутаг дэвсгэрийн хэмжээ: 216 га

Өрх: 2230

Хүн ам: 7590

Малын тоо толгой: 1724

2 дугаар хорооны Засаг даргаар ажиллаж байсан хүмүүс:

1989-2000 онд Ч.Батаа

2008-2010 онд Д.Эрдэнэцогт

2000-2003 онд Ц.Мөнхтогтох  
2003-2008 онд Б.Лхагвасүрэн

2010-2012 онд Б.Мягмарцэрэн  
2012 оноос Ж.Нямсүрэн

### ГУРАВДУГААР ХОРОО



1951 онд их уурхай байгуулагдснаар Жамбалжав даргатай Хорин байгуулагдсан бөгөөд 1992 онд нийслэлийн Налайх дүүргийн 3 дугаар хороо болсон.

Тус хороо нь Буурал, Хөндлөн, Шохой, Тайжийн даваа, уурхайн эдэлбэр газар, Налайхын гол зэрэг нутаг дэвсгэрийг харьяалдаг.

Хорооны Засаг даргаар С.Цэрэвсамбуу ажиллаж байна.



Нутаг дэвсгэрийн хэмжээ: 18292 га

Өрх: 1478

Хүн ам: 5282

Малын тоо толгой: 7722

3 дугаар хорооны Засаг даргаар ажиллаж байсан хүмүүс:

1992-1998 онд О.Балжинням

1998-2000 онд Д.Найдансүрэн

2000-2008 онд Ш.Ванганжил

2008-2012 онд Ч.Оргилмаа

2012 оноос С.Цэрэвсамбуу

## ДӨРӨВДҮГЭЭР ХОРОО



Налайхын уурхайд зохион байгуулалттайгаар ажиллах хүчин элсүүлэлтээр ирж, суурьшсан баруун аймгийн иргэдээс голдуу бүрдсэн 7, 8 дугаар хорин болж, 1960-аад оноос Налайхын их уурхайн баруун талд “Сайрын худаг” нэртэй газраас бууриа сэлгэж, “Дэнж” буюу одоогийн 3, 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 4, 5 дугаар хороо болж хуваагдсан байна.

1992 онд нийслэлийн Налайх дүүргийн 4 дүгээр хороо болсон бөгөөд хорооны Засаг даргаар С.Медалбек ажиллаж байна.



Нутаг дэвсгэрийн хэмжээ: 1222 га

Өрх: 1557

Хүн ам: 6422

Малын тоо толгой: 7210

4 дүгээр хорооны Засаг даргаар ажиллаж байсан хүмүүс:

1992-1994 онд н.Цэдэнбалжир

2000-2007 онд Т.Ахаагаа

1994-1997 онд А.Орногбай

2007-2008 онд А.Булбул

1997-1998 онд Х.Кайрол

2008-2012 онд О.Манарбек

1998-2000 онд Х.Батаа

2012 оноос С.Медалбек

## ТАВДУГААР ХОРОО



Налайхад байрлаж байсан Зөвлөлтийн цэргийн ангийг нутаг буцахад тус ангид алба хааж байсан офицер, албан хаагчид тэдний ар гэрийнхэний амьдарч байсан “Городок” хэмээх орос нэрээр нэрлэгдсэн суурин, Зэвсэгт хүчний 337-р ангийг түшиглэн 1990 оны 7 дугаар сард Налайхын районы 10 дугаар хороо болон анх байгуулагджээ. Тус хороонд Аржанчивлан, Харзтай, Шохой цагаан булаг, Уубулан зэрэг газар нутаг хамрагддаг. Хорооны Засаг даргаар Г.Талстболор ажиллаж байна.



Нутаг дэвсгэрийн хэмжээ: 17441га

Өрх: 834

Хүн ам: 2585

Малын тоо толгой: 8602

5 дугаар хорооны Засаг даргаар ажиллаж байсан хүмүүс:

1990-1992 онд Ж.Аюушрагчаа

1992-1995 онд О.Нямсүрэн

1995-1998 онд А.Ганхуяг

1998-2001 онд С.Цэгмэд

2001-2004 онд Б.Мягмарсүрэн

2004-2008 онд Ц.Энхбаяр

2008-2009 онд Л.Мөнхцэцэг

2009-2012 онд Ц.Энхбаяр

2012 оноос Г.Талстболор

## ЗУРГААДУГААР ХОРОО



Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2001 оны 2 дугаар сарын 22-ны 33 дугаар тогтоолоор байгуулагдаж, дүүргийн Засаг даргын 2001 оны 3 сарын 13-ны өдрийн Б/13 дугаар захирамжаар Д.Лочинг хорооны анхны Засаг даргаар томилсон.

Хан Хэнтий тусгай хамгаалалттай газрын Горхи, Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт байрладаг.

Хорооны Засаг даргаар И.Энхбаатар ажиллаж байна.



Нутаг дэвсгэрийн хэмжээ: 25381га

Өрх: 575

Хүн ам: 1479

Малын тоо толгой: 8052

6-р хорооны Засаг даргаар ажиллаж байсан хүмүүс:

2001-2008 онд Д.Лочин

2009-2012 онд П.Нарантуяа

2012 оноос И.Энхбаатар



## ДОЛООДУГААР ХОРОО



Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 12 дугаар сарын 24-ний 6/48 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2011 оны 27 дугаар захирамжаар 2011 оны 2 дугаар сард Нэгдүгээр хорооноос өрх тусгаарлаж байгуулагдсан.

2012 оноос хорооны Засаг даргаар С.Тунгалаг ажиллаж байна.




Нутаг дэвсгэрийн хэмжээ: 319 га

Өрх: 1137

Хүн ам: 4230

Малын тоо толгой: 2187

## БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦАР ХҮРЭЭ, ХАРЬЯА ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮН: ЦАГДААГИЙН ХЭЛТЭС



1930-аад оны эхээр зарим аймгуудад цагдан сэргийлэх анги байгуулагдаж эхлэх үеэс 1935 онд Налайхын нүүрсний үйлдвэрийн цагдан сэргийлэх харуулын пост /дарга нь бага дарга Заграа/ байгуулсан нь Цагдаагийн хэлтсийн эх суурь болсон байна.

1942 онд Налайхын төмөр замыг хамгаалах зорилготойгоор орон тоо нэмэгдэж, улмаар Дотоод Явдлын Яамны Сайдын 1952 оны 3 дугаар сарын 14-ний 170 дугаар тушаалаар Улаанбаатар хотын 10 дугаар хорооны 5 дугаар Цагдан сэргийлэх анги нэртэй болж,

ангийн даргаар А.Ишжамц томилогдсон байна.

Цагдан сэргийлэх ангийн даргаар 1953-1955 онд ахмад Сүрэнхорлоо, 1956-1957 онд хошууч н.Аюуш, н.Шагдар, 1958-1960 онд дэд Ч.Саарал, 1960-1963 онд хошууч н.Жанцан ажиллаж байжээ.

1945 онд Налайхын цагдаагийн 15 ажилтныг дайнд явуулж, 1952 он хүртэл цөөн хүнтэйгээр ажил үүргээ нэр төртэй биелүүлж иржээ. НАХЯ-ны сайдын 1958 оны 6 дугаар сарын 25-ны 298 дугаар тушаалаар Улаанбаатар хотын цагдан сэргийлэх газрын зохион байгуулалтад орж Налайх хотын Цагдан сэргийлэх ангийг 6 дугаар анги болгон даргаар дэд хурандаа Чойвонгийн Саарал томилогдон, энэ үеэс гал команд, харуулын гэрээт салаа тус бүр 30 гаруй хүнтэй ажил үүргээ гүйцэтгэж байжээ. Налайх дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтэс нь цагдаагийн албаны шинэ хууль батлагдснаар ЦЕГ-ын даргын 2014 оны 5 дугаар сарын 06-ны 315 дугаар тушаалаар Налайх дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс болж өөрчлөгдсөн.

Цагдаагийн хэлтсийн даргаар ажиллаж байсан хүмүүс:

Хурандаа Ч.Самдан	1971-1976 он
Дэд хурандаа Д.Даваа	1976-1987 он
Дэд хурандаа Г.Гонгор	1987-1990 он
Хурандаа Б.Лувсанцэрэн	1990-1997 он
Хошууч Б.Энхбат	1997-1998 он
Хурандаа Ц.Баярсайхан	1998-2001 он
Хурандаа З.Сайжрах	2001-2005 он
Хурандаа М.Энхбаяр	2005-2008 он

Дэд хурандаа Д.Энхбаяр 2008-2012 он

Хурандаа Д.Болдбаатар 2012-2013 он

Дэд хурандаа С.Од 2013-2014 он

2014 оноос хурандаа С.Буянжаргал ажиллаж байна.

## ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС



1932 онд анх уурхайн галын аюулгүй байдлыг хариуцсан галын байцаагчаар Б.Жамсранг томилон ажиллуулжээ. 1934 онд нүүрсний уурхайн харьяа гал түймэр эсэргүүцэн сөнөөх анхны албыг дарга, номын багш, гал унтраагч гэсэн 10 шахам орон тоотойгоор байгуулж уурхайн хятад ажилчдын гуанз байсан “Хоолон гэр” буюу “Тогоо байшин”-ийн нэг өрөөнд байрлаж байв.

1936 онд Гал командыг өргөтгөж хагас цэргийн зохион байгуулалттай, болгож, командын дарга, орлогч, ээлжийн бага дарга, жолооч, утасны дежур, гал сөнөөгч гэсэн орон тоотой ажиллаж байв. 1937 онд галын анхны ЗИС-5АМ ачааны авто машинтай болжээ. 1952 онд шинээр Зис-5 галын машин авч “Тогоо байшин”-г дахин засварлаж шинээр гараш гарган хажууд нь гэр барьж цэргийн болон ажилчдын байр гаргажээ. Гал түймэр гарсан үед харанга цохих, дун бүрээ үлээх зэргээр дохио өгч цуглуулдаг байжээ.

1954 онд Гал командыг татан буулгаж, энгийн 10 орон тоотой болгон цомотгожээ.

1955 оны 10 дугаар сарын 1-нд нүүрсний үйдвэрийн харьяа гэрээт гал командыг байгуулж, галын 2 авто машин авч командын дарга, салааны дарга гэсэн 4 офицер, 6 жолооч-ахлагч, 21 гал сөнөөгч-байлдагчтай цэргийн зохион байгуулалттайгаар ажиллах болсон.

1964 онд 3 айлын орон сууцны байр авч контор, цэргийн байр, жижүүрийн өрөө, Сүхбаатарын тасалгаа, гал зуух болгон засварлан байрлаж Гал түймэр эсэргүүцэгч ЗИЛ-150 авто машинтай болсон.

1962 онд БНМАУ-ын СНЗ-ийн 206 дугаар тогтоолоор уурхайн харьяа гэрээт гал командыг татан буулгаж налайх хотыг хариуцсан Улсын гал команд болгож хотын төсөвт багтаан, шинээр ЗИЛ164 машин өгч, 4 машинтайгаар өргөтгөж, одоогийн галын ангийн эхлэл тавигджээ.

1967-1971 ЗИС-5АМ, ЗИЛ-130 машинуудыг акталж, ГАЗ-51, ЗИЛ-154 маркийн галын зориулалтын автоцистерн машинтай болжээ.

1968 онд УУЦСЕГ, ХХҮЯ-ны хамтарсан гэрээний дагуу Налайхын Шилний үйлдвэрийн дэргэд галын гэрээт пост шинээр байгуулагдан анхны даргаар Д.Дагва ажиллав.

1990 онд Монгол улсын Засгийн газрын 107 дугаар тогтоолоор улсын хэмжээний бүх гал командуудыг цагдан сэргийлэх байгууллагын харъяаллаас өөрчлөн санхүү, төсөв, албан үүргийн хувьд бие даалган орон нутгийн мэдэлд шилжүүлэн “Гал унтраах анги” гэж өөрчилсөн.

Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 51 дүгээр тогтоолоор гамшгаас хамгаалах штаб, 2005 оны 48 дугаар тогтоолоор Онцгой байдлын хэлтэс болсон.

Гал команд-Онцгой байдлын хэлтсийн даргаар ажиллаж байсан хүмүүс:

1934-1936 онд Д.Пэрэнлэй

1964-1967 онд Гэндэнгүр

1936-1945 онд Б.Нанзад

1967-1971 онд С.Чойном хошууч

1945-1952 онд П.Шагдарсүрэн

1971-1974 онд Д.Цэрэндовдон

1952-1956 онд Б.Буянтогтох- хошууч

1974-1986 онд Б.Доржсүрэн хошууч

1956-1957 онд н.Дашзэвэг

1986-2011 онд Х.Дамжин- хурандаа

1957-1964 онд Ёндон хошууч

2011 оноос хурандаа Д.Даваасүрэн ажиллаж байна.

## СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



1992-1997 онд Статистикийн алба нь Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн статистикч-эдийн засагч, статистикийн ажил үүргийг хариуцан гүйцэтгэж байгаад Статистикийн тухай Монгол улсын хууль, УИХ-ын 1997 оны 45 дугаар тогтоол, Үндэсний статистикийн газрын даргын 1997 оны 82 дугаар тушаал, Налайх дүүргийн Засаг даргын захирамжаар 1997 оны 8 дугаар сарын 01-нээс эхлэн бие даасан төсөвтэй Статистикийн тасаг болсон.

2004 онд “Статистикийн тухай” Монгол Улсын хуульд нэмэлт өөрчлөлт орсны дагуу хэлтэс болж, дүүргийн эдийн засгийн байдлыг статистик тоон үзүүлэлтүүдээр гаргаж, үйл ажиллагааны өсөлт бууралт, хандлагад үнэлэлт дүгнэлт өгч, дүүргийн удирдлагыг шаардлагатай мэдээллээр тасралтгүй ханган ажиллаж байна.

Статистикч, хэлтсийн даргаар ажиллаж байсан хүмүүс:

1962-1971 онд О.Дүгэрээ

1997-1999 онд Т.Сатыбалды

1972-1974 онд М.Зина

1999-2012 онд Ж.Буд

1975-1991 онд Д.Нацаг

2012-2013 онд Б.Гонгорсүрэн

1992-1997 онд Д.Умбаруу

2014 оны 05 дугаар сараас Д.Цэнд

### **БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС**

Иргэний гэр бүлийн бүртгэлийн ажлыг 1962-1981 онд М.Зина, 1981-1990 онд Х.Пунцагмаа, 1990-1992 онд Ж.Мөнхцэцэг, 1992-1998 онд В.Бадамцэцэг, 1998-2005 онд Д.Тунгалаг нар хийж иржээ. Дүүргийн Засаг даргын 2005 оны 2 дугаар сарын 14-ний 37 дугаар захирамжаар Тамгын газрын Төрийн захиргааны хэлтсийг бүртгэл, мэдээллийн тасагтай байхаар зохион байгуулсан. Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2012 оны 4 дүгээр сарын 09-ний 277 дугаар тушаалаар Налайх дүүргийн Бүртгэлийн хэлтэс болж өргөжсөн. Бүртгэл, мэдээллийн тасгийн даргаас эхлэн Бүртгэлийн хэлтсийн даргаар 2005 оноос О.Нямсүрэн ажиллаж байна.



## МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ХЭЛТЭС



Нийслэлийн Мэргэжлийн хяналтын албаны даргын 2003 оны 4 дүгээр тушаалаар Налайх дүүрэг дэх хяналтын хэсэг нэртэй байгуулагдсан. Улсын мэргэжлийн хяналтын газрын даргын 2005 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 21 дүгээр тушаалаар Налайх дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс болсон.

## ӨМЧ, ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ АЛБА



Налайхын ройаны АДХ-ын Гүйцэтгэх Захиргаанд архитектур, газар олголт, улаан шугам тавих ажлыг З.Эрдэнэхүү, Үйтүмэн нар 1986-1995 онд хариуцан ажиллаж байжээ.

Нийслэлийн Газрын албаны даргын 01 дүгээр тушаалаар Налайх дүүргийн Хот байгуулалт, газрын харилцааны алба нэртэйгээр анх байгуулагдаж, 2001-2003 он хүртэл Л.Цогтхүү даргаар нь ажиллаж байсан.

Нийслэлийн Газрын албаны даргын 2003 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 11 дүгээр тушаалаар Налайх дүүргийн Газрын алба нэртэйгээр шинэчлэн байгуулжээ.

Энэ үед 2003-2004 онд албаны даргаар Г.Энхцэцэг, 2004-2013 он хүртэл С.Санжмятав, 2013 оноос М.Мэндсайхан томилогдон ажиллаж байна.

## ТАТВАРЫН ХЭЛТЭС



Татварын хэлтсийн дарга  
С.Ялалт

Монгол Улсын Засгийн газрын 1990 оны 204 дүгээр тогтоолоор Налайхын районы АДХГЗ-ны санхүүгийн хэлтсийн мэргэжилтнүүдээс албан татварын тасгийн анхны мэргэшсэн боловсон хүчин бүрджээ.

Дарга нь Б.Сайн-Амгалан, татварын ахлах байцаагч С.Лхамжав, татварын орлогын байцаагч Г.Долгорсүрэн, улсын бүртгэл хариуцсан татварын байцаагч, хэлтсийн нягтлан бодогч Д.Мягмаржав нар анх томилогдон ажиллаж эхэлжээ.

Монгол Улсын Засгийн газрын 1992 оны 17 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, ҮТЕГ-ын даргын 217/5 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын А/306 дугаар захирамжаар 1992 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс Татварын хэлтэс болсон.

Татварын хэлтсийн даргаар ажиллаж байсан хүмүүс:

Б.Сайн-Амгалан	1992-1994 он	Д.Умбаруу	2000-2008 он
С.Лхамжав	1994-1998 он	Н.Энхээ	2008-2009 он
Г.Ганбат	1998-1999 он	Д.Энхбаяр	2009-2012 он
Т.Сатыбалды	1999-2000 он	С.Ялалт	2013 оноос

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС



1958 онд Налайхын Их уурхайн Үйлдвэрчний эвлэлийн хорооны бүтцэд тэтгэвэр, тэтгэмж хариуцсан ажилтны орон тоо батлагдсанаар Налайх хотын нийгмийн даатгалын байгууллагын суурь тавигджээ.

Нийгмийн даатгалын ажил үйлчилгээг төр өөрийн мэдэлд шилжүүлж авсанаар Налайхын районы АДХГЗ-ны дэргэдэх Нийгмийн хангамжийн хэлтэс, 1995 оноос Налайх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс болсон.

Нийгэм хангамжийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтсийн даргаар ажиллаж байсан хүмүүс:

1992 онд Д.Гармаа	2001-2004 онд Г.Чулуунбат
1992-1993 онд Э.Батдорж	2005-2013 онд Ч.Чулуунчимэг
1993-1994 онд Дэчинравдан	2013 оноос Н.Өнөржаргал нар ажиллаж байна.
1994-2001 онд Г.Санжид	

## **ХӨДӨЛМӨРИЙН ХЭЛТЭС**



Шинэчлэлийн Засгийн газраас Хөдөлмөрийн яамыг шинээр байгуулж, хүн амын хөдөлмөр эрхлэлт, өрхийн амьжиргааг дээшлүүлэх талаар онцгой анхаарч, 2012 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 36 дугаар тогтоолоор аймаг, нийслэл, дүүрэгт Хөдөлмөрийн хэлтэс байгуулагдсан. Хэлтсийн даргаар Д.Нямсүрэн ажиллаж байна.

## **ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТӨВ**



Дүүргийн Засаг даргын захирамжаар 2013 онд байгуулагдсан тус төв жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллаж байна. Тус төвийн даргаар Г.Гантөмөр ажиллаж байна.

## **НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**



1990-1997 онд Хөдөлмөр, нийгмийн хангамжийн хэлтэс нэртэй ажиллаж байгаад Нийгмийн даатгалын багц хууль батлагдан гарснаар Нийгмийн даатгалын хэлтэс, Нийгмийн халамжийн төв, Хөдөлмөр зохицуулалтын алба гэсэн 3 тусдаа алба байгууллага болон ажиллаж эхэлсэн.

Монгол Упсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 175, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2004 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 25 дугаар тушаалаар

Хөдөлмөр эрхлэлтийн алба, Нийгмийн халамжийн төв нэгдэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс болсон.



Засгийн газрын бүтцэд өөрчлөлт орж Хүн амын хөгжил-Нийгмийн хамгааллын Яаманд харьяалагдах болсноор Нийгмийн халамжийн үйлчилгээний хэлтэс болсон.

Байгууллагын даргаар ажиллаж байсан хүмүүс:

Нийгмийн халамжийн төвийн даргаар

1998-2000 онд С.Гэлэгжамц

2000-2004 онд П.Чинбат

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Нийгмийн халамжийн үйлчилгээний хэлтсийн даргаар 2005 оноос П.Чинбат ажиллаж байна.

### **АЛБАН БУС-НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВ:**



Хүн амд хэрэгцээтэй боловсролыг сургуулиас гадуур, боллоцоотой хугацаанд, тохиромжтой хэлбэрээр, тасралтгүй эзэмшүүлэх зорилготойгоор Налайх дүүргийн Засаг даргын 2010 оны 136 дугаар захирамжаар Албан бус боловсролын төв, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2013 оны А/1102 дугаар захирамжаар Албан бус-Насан туршийн боловсролын төвийг байгуулсан.

Төвийн захирлаар Д.Нансалмаа ажиллаж байна.

### **БОЛОВСРОЛЫН ХЭЛТЭС**



Налайх хотын АДХГЗ-нд боловсролын асуудлыг 1 ажилтан хариуцаж байсныг 1962 онд Гэгээрэл, соёлын хэлтэс байгуулан 2 ажилтантай болгож, 1975-1993 онд Ардын боловсролын хэлтэс, 1993-1998 онд Боловсролын алба, 1998-2001 онд Сургалт арга зүйн төв, 2001-2008 онд Соёл, боловсролын төв нэртэй ажиллаж ирсэн ба Нийслэлийн Засаг даргын 2008 оны 73 дугаар захирамжаар Боловсролын хэлтэс болон ажиллаж, хэлтсийн даргаар П.Амгалан ажиллаж байна.

## **ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ**



Налайх дүүргийн Засаг даргын 2009 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 25 дугаар захирамжаар 9 хүний бүтэц, орон тоотойгоор байгуулагдсан.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2013 оны А/03 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2013 оны 14 дүгээр захирамжаар Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төв болсон ба анхны даргаар

Б.Галбадрах, 2012 оноос төвийн даргаар Б.Наранбаяр ажиллаж байна.

## **ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА**



Налайх дүүргийн Засаг даргын 2013 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 31 дүгээр захирамжаар байгуулагдсан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий Засаг даргын дэргэдэх алба юм. Албаны даргаар Ж.Бадамцэцэг ажиллаж байна.

## **ДОТООД АУДИТЫН АЛБА**



Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд, тухайн өмч давамгайлсан байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн, улсын болон орон нутгийн төсөв, хөрөнгийн зарцуулалт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд дотоод аудит хийн, дүгнэлт, зөвлөмж гаргаж ажиллах үндсэн үүрэгтэйгээр Налайх дүүргийн Засаг даргын 2013 оны 12 дугаар сарын

23-ний өдрийн Б/57 дугаар захирамжаар байгуулагдсан шинэхэн байгууллага юм. Албаны даргаар Н.Болормаа ажиллаж байна.

**ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН  
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2010	2011	2012	2013
<b>Суурин хүн ам</b>	Тоо	31458	32513	32893	33235
<b>Шинээр төрсөн хүүхэд</b>	Тоо	796	881	874	969
<b>Нас баралт</b>	Тоо	261	314	236	232
<b>Шилжиж ирсэн хүн</b>	Тоо	2914	2431	2461	2884
<b>Шилжиж явсан хүн</b>	Тоо	2323	2135	2733	2693
<b>Ажилгүйчүүд</b>	Тоо	219	1300	1395	960
<b>Өрх толгойлсон эмэгтэйчүүд</b>	Тоо	1282	1347	1359	1665
<b>Тахир дутуу хүн</b>	Тоо	1436	1394	1315	1628
<b>Бүтэн өнчин хүүхэд</b>	Тоо	57	59	58	64
<b>Хагас өнчин хүүхэд</b>	Тоо	517	505	526	532
<b>Халдварт өвчин</b>	Тоо	157	294	174	251
<b>Бүртгэгдсэн гэмт хэрэг</b>	Тоо	302	242	290	302
<b>Төсвийн орлого</b>	Мян.төг	394406.0	461852,2	483879,5	760249,2
<b>Төсвийн зарлага</b>	Мян.төг	8625943.9	8310151,3	11259686,4	15217910,6
<b>Малын тоо</b>	Тоо	39709	40568	39986	45160
<b>Нийт авто машин</b>	Тоо	2516	2965	3505	1946*

\*- үзлэгт хамрагдсан байдлаар

**ДҮҮРГИЙН ТЭСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА**

Дүүргийн орон нутгийн төсвийн орлого 760249.2 мянган төгрөг болж, төсвийн орлогын төлөвлөгөө 105.6%-аар, татварын орлогын төлөвлөгөө 105.5%-иар, татварын бус орлогын төлөвлөгөө 162.3%-иар тус тус биелэсэн байна.


Нийт орлогын 77.4 %-ийг татварын орлого, 22.6 %-ийг татаварын бус орлого бүрдүүлжээ. Орлогын албан татварын 60,4 %-ийг хүн амын орлогын албан татвар, 0.2 %-ийг өмчийн татвар, 39,4 %-ийг бусад татварын орлогоор тус тус бүрдүүлсэн байна.

/мян.төг/


№	Үзүүлэлт	2012 он	2013 он			2013 2012 хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	
<b>I НИЙТ ОРЛОГО</b>		<b>4118769.5</b>	<b>15345682,8</b>	<b>15385727,0</b>	<b>100,3</b>	<b>373,5</b>
<b>TOTAL REVENUE</b>						
1.	Татварын орлого	444983.5	720205,0	760249,2	105,6	170.8
	1.1. Орлогын албан татвар	295470.3	614400,0	588488,8	95,8	199.2
	1.1.1.Хүн амын орлогын алба татвар	206430.8	280200,0	355581,8	126,9	172.3
	1.1.2. Өмчийн татвар	1248.0	1200,0	1175,5	97,9	94.2
	1.1.3. Бусад татвар	87791.5	333000,0	231731,5	69,6	264.0
2.	Татварын бус орлого	149513.2	105805,0	171760,4	162,3	114.9
3.	Хөрөнгийн орлого	38896.0	0	0	0	0
4.	Тусламжийн орлого	3634890,0	14625477,8	14625477,8	100,0	402,4
<b>II. НИЙТ ЗАРЛАГА</b>		<b>11259686.4</b>	<b>15378692,4</b>	<b>15217910.6</b>	<b>98,9</b>	<b>135,2</b>
1.	Цалин хөлс	7418644.5	5834337,4	5921341.5	101,5	79,8
2.	<i>Ндаатгал, ЭМД-ын шимтгэл</i>	700361.7	638202,3	639506.4	100,2	91,3
3.	Бараа үйлчилгээний зардал	2905983.6	4210798,9	4125581.8	98,0	142,0
4.	Татаас ба урсгал шилжүүлэг	234696.6	2947732,1	2783859.2	94,4	1186,2
5.	Хөрөнгийн зардал	0	1747621,7	1747621,7	100,0	-

Энэ онд төсвийн зарлагын санхүүжилт 15217910,6 мянган төгрөг болж, үүний 38,9 %-ийг цалин хөлсөнд, 4,2%-ийг нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлд, 27,1%-ийг бараа үйлчилгээний зардалд, 18,3%-ийг татаас ба урсгал шилжүүлэгт, 11,5 %-ийг хөрөнгийн зардалд тус тус зарцуулсан байна.

### Төсвийн орлогын бүрдэлт



### Төсвийн зарлагын бүтэц



**ӨРХ, ХҮН АМЫН ТОО**


		2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	<u>2013</u> 2012 %
<b>Ерхийн тоо</b>		<b>8527</b>	<b>8826</b>	<b>8992</b>	<b>9108</b>	<b>9294</b>	<b>102,0</b>
<b>Үүнээс:</b>	1-р хороо	2543	2641	1590	1586	1483	93,5
	2-р хороо	2093	2156	2210	2215	2230	100,7
	3-р хороо	1360	1414	1442	1433	1478	103,1
	4-р хороо	1336	1397	1458	1526	1557	102,0
	5-р хороо	665	686	748	778	834	107,2
	6-р хороо	530	532	543	555	575	103,6
	7-р хороо	-	-	1001	1015	1137	112,0
<b>Хүн амын тоо</b>		<b>30215</b>	<b>31458</b>	<b>32513</b>	<b>32893</b>	<b>33235</b>	<b>101,0</b>
Үүнээс: эмэгтэй		15412	15894	16392	16223	16717	101,6
<b>Үүнээс:</b>	<b>1-р хороо</b>	<b>9263</b>	<b>9878</b>	<b>6041</b>	<b>6050</b>	<b>5647</b>	<b>93,3</b>
	Үүнээс: эмэгтэй	4698	4999	3051	3003	2934	97,7
	<b>2-р хороо</b>	<b>7058</b>	<b>7210</b>	<b>7451</b>	<b>7475</b>	<b>7590</b>	<b>101,5</b>
	Үүнээс: эмэгтэй	3606	3675	3817	3599	3816	106,0
	<b>3-р хороо</b>	<b>5072</b>	<b>5177</b>	<b>5330</b>	<b>5229</b>	<b>5282</b>	<b>101,0</b>
	Үүнээс: эмэгтэй	2589	2551	2641	2637	2629	99,7
	<b>4-р хороо</b>	<b>5442</b>	<b>5706</b>	<b>5955</b>	<b>6131</b>	<b>6422</b>	<b>104,7</b>
	Үүнээс: эмэгтэй	2759	2863	2984	3029	3160	104,3
	<b>5-р хороо</b>	<b>2079</b>	<b>2182</b>	<b>2407</b>	<b>2458</b>	<b>2585</b>	<b>105,2</b>
	Үүнээс эмэгтэй	1070	1122	1219	1228	1284	104,6

	<b>6-р хороо</b>	<b>1301</b>	<b>1305</b>	<b>1381</b>	<b>1456</b>	<b>1479</b>	<b>101,6</b>
	Үүнээс эмэгтэй	690	684	684	708	756	106,8
	<b>7-р хороо</b>	-	-	<b>3948</b>	<b>4094</b>	<b>4230</b>	<b>103,3</b>
	Үүнээс эмэгтэй	-	-	1996	2019	2138	105,9
<b>Нийт хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувь</b>		<b>51,0</b>	<b>50,5</b>	<b>50,4</b>	<b>49,3</b>	<b>50,3</b>	<b>102,0</b>
<b>Нэг ерхэд ногдох хүний тоо</b>		<b>3,5</b>	<b>3,6</b>	<b>3,6</b>	<b>3,6</b>	<b>3,6</b>	<b>100,0</b>


Дүүргийн хэмжээнд 9294 ерхийн 33235 хүн тоологдож өнгөрсөн оны мөн үеэс 342 хүн буюу 1.0 %- иар өссөн байна. Үүнээс эрэгтэй 16518, эмэгтэй 16717 байна. Дүүргийн нийт хүн амд эмэгтэйчүүд 50.3 %-ийг эзэлж, нэг ерхэд 3.6 хүн ногдож байна.

97-оос дээш насны 4 иргэн амьдарч байгаагийн хамгийн өндөр настан нь 1-р хорооны иргэн Д.Надмид 108 нас хүрсэн байна.

### Хүн амын тоо хороогоор



**Ажиллагсад, эдийн засгийн идэвхитэй хүн ам**  
**Ажиллагсадыг графикаар харуулбал**



**ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИТЭЙ ХҮН АМ**

	2007 он	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он
Эдийн засгийн идэвхитэй хүн ам	10557	10821	11086	11477	11613	12973	12854
Ажиллагсад	10279	10689	10984	11258	11465	11578	11894
Ажилгүйчүүд	278	132	102	219	148	1395	960
Ажилгүйдлийн түвшин %	2.6	1.2	0.9	1.9	1.3	10.7	7.5
Нийт хүн ам	26992	28862	30215	31458	32513	32893	33234
Нийт хүн амд эдийн засгийн идэвхитэй хүн амын эзлэх хувийн жин	39.1	37.5	36.6	36.5	35.7	39.4	38.7
Хөдөлмөрийн насны нийт хүн ам	17538	18742	19482	20147	20752	20563	19618



ТҮНЭЭС	1-р хороо	4947	5530	5884	6254	3791	3719	3508
	2-р хороо	4388	4683	4806	4875	5007	4906	4608
	3-р хороо	2949	3193	3260	3256	3421	3235	2957
	4-р хороо	3247	3266	3364	3502	3634	3670	3799
	5-р хороо	1324	1338	1352	1441	1557	1553	1468
	6-р хороо	683	732	816	819	889	914	825
	7-р хороо	-	-	-	-	2453	2566	2453
Хөдөлмөрийн насны нийт хүн амд эдийн засгийн идэвхитэй хүн амын эзлэх хувийн жин		60.2	57.7	56.9	57.0	56.0	63.1	65.5
Нийт хүн амд ажиллагсдын эзлэх хувийн жин		38.1	37.0	36.3	35.8	35.3	35.2	35.8
Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүн ам		1665	1400	1291	1297	1018	986	921

**Тайлбар:** Ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн ам нь АЖИЛЛАГСАД, хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй АЖИЛГҮЙЧҮҮД-ийн нийлбэр юм.

2013 онд ЭЗИХА өнгөрсөн оны мөн үеэс 119 хүнээр буюу 0,9 %-иар буурчээ. Ажилгүйдлийн түвшин нь 7,5 % байна.

Нийт хүн амд эдийн засгийн идэвхитэй хүн амын эзлэх хувийн жин 38,7 % байна.

## АЖИЛГҮЙДЭЛ

### Ажилгүйчүүдийн тоо


	2012 он	2013 он	тоо	хувь
1. Өмнөх сарын эцэст байсан ажилгүйчүүд	1419	1306	-113	92,0
Үүнээс: эмэгтэй	794	736	-58	92,7
2. Тайлант сард нэмэгдсэн ажилгүйчүүд	31	0	-31	0
3. Ажилгүйчүүдээс тайлант сард ажилд орсон	11	39	28	354,5
4. Тайлант сард ажилгүйчүүдийн бүртгэлээс хасагдсан	55	346	291	629,1
5. Тайлант сарын эцэст байгаа ажилгүйчүүд	<b>1395</b>	<b>960</b>	-435	68,8
үүнээс: эмэгтэй	784	556	-228	70,9

Хөдөлмөрийн хэлтэст 2013 оны 12-р сарын эцэст 960 хүн бүртгэлтэй байгаагийн 57.9 хувь нь эмэгтэйчүүд, 27 буюу 2,8 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзэхэд бүртгэлтэй ажилгүйчүүд 435 буюу 31,2 хувиар, эмэгтэйчүүд 228 буюу 29,1 хувиар тус тус буурсан байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 23,0 хувь нь 15-24 насныхан, 33,7 хувь нь 25-34 насныхан, 25,4 хувь нь 35-44 насныхан, 17,8 хувь нь 45-59 насныхан байна.

### Ажилгүйчүүд /боловсрол, насаар/

Үзүүлэлт	12-р сар		Өсөлт бууралт	
	2012 он	2013 он	Тоо	хувь
<b>Ажилгүйчүүд-бүгд</b>	<b>1395</b>	<b>960</b>	<b>-435</b>	<b>68,8</b>
-дээд	197	131	-66	66,5
-тусгай дунд	71	33	-38	46,5
-мэргэжлийн анхан шатны	184	96	-88	52,2
-бүрэн дунд	642	567	-75	88,3



-бүрэн бус дунд	240	108	-132	45,0
-бага	43	15	-28	34,9
-боловсролгүй	18	10	-8	55,6


Хөдөлмөрийн чадвартай ажиллахад бэлэн ажил идэвхитэй эрж байгаа ХХэлтэст біртгэлтэй ажилгүйчүүдийн 13,6% нь дээд боловсролтой, 3,4% нь тусгай дунд, 10,0% нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 59,1% нь бүрэн дунд, 11,2% нь бүрэн бус дунд боловсролтой, 1,6% нь бага боловсролтой, 1,0% нь боловсролгүй хүмүүс байна.

### Амьжиргааны доод түвшин

2004 он	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он
26400 төгрөг	30000 төгрөг	42800 төгрөг	60100 төгрөг	94800 төгрөг	101100 төгрөг	101600 төгрөг	118100 төгрөг	126500 төгрөг	149900 төгрөг

Амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой ерхийн 1 хүнд ногдох орлого нь 2013 онд 149900 төгрөг болсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзэхэд 18,5 %-иар буюу 23400 төгрөгөөр өссөн байна.

### Амьжиргааны доод түвшин 2004-2013 онд



## БОЛОВСРОЛ, СОЁЛ, БИЕИЙН ТАМИР

### Ерөнхий боловсролын сургууль

Үзүүлэлт		2013-2014 онд							
		Голомт цогцолбор	Эрдмийн оргил цогцолбор	Чандмань цогцолбор	109-р бага сургууль	119-р сургууль	Хос уянга	Чандмань эрдэнэ	Нийт дүн
1.	Нийт бүлгийн тоо	52	49	19	12	47	4	5	<b>188</b>
2.	Суралцагчид	1727	1425	429	383	1568	70	26	<b>5628</b>
		Элсэлт							
3.	1-р анги	249	146	54	69	172	19		<b>709</b>
	11-р анги	117	144	42		154			<b>457</b>
4.	Багш нарын тоо	81	76	25	14	73	8	6	<b>283</b>
	Бага ангийн багш	28	22	10	12	22	6	1	<b>101</b>
	Дунд, ахлах ангийн багш	53	54	15	2	51	2	5	<b>182</b>


Нийт 283 багш ажиллаж байгаагийн 24 буюу 8,5 % нь магистр, 201 буюу 71,0 % нь бакалавр, 58 буюу 20,5 % нь дипломын боловсролтой байна. Нийт багш нарын 30,0 % нь 30 хүртэл насны, 37,1 % нь 30-39 насны, 19,8 % нь 40-49 насны, 13,1 % нь 50-59 насныхан байна.

Сургуулийн өмнөх боловсролыг хөгжлийн бэрхшээлтэй 20 хүүхэд эзэмшиж байгаагийн 3 нь харах, 5 нь сонсох, 3 нь хэл ярианы, 3 нь оюун ухааны, 6 нь бие эрхтэний бэрхшээлтэй хүүхдүүд байна.

Сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг нийт 14 барилгад явуулж байгаагийн 8 барилга нь стандартын, 6 барилга нь стандартын бус байна.

Ерөнхий боловсролын сургууль:

Сургуулийн өмнөх боловсрол:



### Нийгмийн даатгал

№	Сангууд	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө /мян.төг/
1	Тэтгэврийн даатгалын сан	4514	5674067,6
2	Тэтгэмжийн даатгалын сан	1198	349992,9
3	Үйлдвэрлэлийн осол, МШӨ-ий даатгалын сан	945	2661451,4
4	Эрүүл мэндийн даатгалын сан	63619	1726137,2
5	Ажилгүйдлийн даатгалын сан	484	168932,2
	<b>Дүн</b>	<b>70760</b>	<b>10580581,3</b>

2013 оны байдлаар нийт 81003 хүнд 13377421,8 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон нь дүүргийн нэг хүн ам 2,4 удаа ямар нэгэн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтөнд хамрагдаж байгааг харуулж байна.

Зөвхөн НДХ-ээс 4514 хүн тэтгэвэр авагчаас 64,2 % нь ендер насны, 27,0 % нь тахир дутуугийн, 8,8 % нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчид байна.

ХҮХ-с 844 хүн халамжийн тэтгэвэр, 461 хүн нөхцөлт мөнгөн тэтгэмж, 272 хүн нийгмийн халамжийн хөнгөлөлт, 1231 хүн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, 3194 хүн ахмад настны хөнгөлөлт, тусламж, 813 хүн хөгжлийн



бэрхшээлтэй иргэний халамж, 977 эх мөнгөн тэтгэмж, 2418 эх алдарт эхийн одонгийн тусламж, 33 ахмад алдар цолтны хөнгөлөлтөд хамрагдсан байна.

## МАЛ АЖ АХУЙ, ГАЗАР ТАРИАЛАН

### Малын тоо хороогоор

	2012 он	2013 он	Үүнээс:					есөлт бууралт	
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	тоо	хувь
1-р хороо	6790	9094	2	520	1369	3958	3245	2304	133,9
2-р хороо	894	1724		167	420	749	388	830	192,8
3-р хороо	5839	7722		1124	871	3328	2399	1883	132,2
4-р хороо	4224	7210	5	553	1112	3247	2293	2986	170,7
5-р хороо	10105	9039	2	647	1714	3690	2986	-784	89,5
6-р хороо	9601	8052	2	1143	3269	1957	1681	-1066	83,9
7-р хороо	2425	2187		209	308	889	781	-238	90,2
<b>Дүн</b>	<b>39878</b>	<b>45028</b>	<b>11</b>	<b>4363</b>	<b>9063</b>	<b>17818</b>	<b>13773</b>	<b>5150</b>	<b>112,9</b>
ААН	108	132		73	59			24	122,2
<b>ДҮН</b>	<b>39986</b>	<b>45160</b>	<b>11</b>	<b>4436</b>	<b>9122</b>	<b>17818</b>	<b>13773</b>	<b>5174</b>	<b>112,9</b>

Дүүргийн хэмжээнд нийт 45160 толгой мал тоологдсоноос иргэдийн мал 45028 толгой, ААНБ-ын 132 толгой мал тоологдож, малын тоо толгой урд оноос 5174 толгой мал буюу 12,9 %-иар өслөө. Оны эцэст 17074 толгой хээлтэгч мал тоологдлоо. Нийт малтай ерх 770, үүнээс малчин ерх 297 байна.



## АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл бие хэмжээгээр

№	Үзүүлэлт	хэмжих нэгж	Жилийн эхнээс ессен дүн		
			2012 он	2013он	хувь
1	Нүүрс	мян.тн	2.7	2.3	85.2
2	Тоосго	мян.ш	14247.5	18686.4	131.2
3	Шохой	м.тн	43.5	38.3	88.0
4	Цемент	м.тн	37.7	36.8	97.6
5	Дулаан	м.г/кал	99.7	98	98.3
6	Эрчим хүч	м.кв.цаг	89396.4	93704.9	104.8
7	Оёдол	мян.ш	14.9	12.3	82.6
8	Талх	тн	27.9	18.7	67.0
9	Ус борлуулалт	мян.тн	1241.3	1453.4	117.1

**Аж үйлдвэрийн салбаруудын борлуулалт /мян.төг/**

№	Үзүүлэлт	ХЭМЖИХ НЭГЖ	Жилийн эхнээс өссөн дүн		
			2012 он	2013 он	хувь
1	Нүүрс	мян.төг	70360.0	106550.0	151.4
2	Тоосго	мян.төг	2850662.7	3168732.0	111.2
3	Шохой	мян.төг	310500.0	279226.0	89.9
4	Цемент	мян.төг	5477572.2	5248210.2	95.8
5	Дулаан	мян.төг	968834.5	1220992.3	126.0
6	Эрчим хүч	мян.төг	8848511.1	10079254.9	113.9
7	Оёдлын үйлдвэр	мян.төг	56768.8	99169.9	174.7
8	Талх,нарийн боов	мян.төг	25320.0	17410.0	68.8
9	Ус борлуулалт	мян.төг	322753.0	428384.1	132.7
	<b>Дүн</b>	<b>мян.төг</b>	18964954.3	20647929.4	108.9

2013 оны эцэст аж үйлдвэрийн салбаруудын нийт борлуулалт 20647929,4 мянган төгрөг болж, ноднингийн мөн үеэс 8,9 %-иар өссө. Нүүрс, тоосго, дулаан, эрчим хүч, оёдлын үйлдвэр, ус борлуулалтын орлого тус бүр 8,9-74,7 %-иар өссөн байна. Харин шохой, цемент, талх, нарийн боовны борлуулалт 4,2-31,2 %-иар буурчээ.

**Худалдааны үзүүлэлтүүд (мян.төг)**

Дүүргийн худалдааны байгууллагууд энэ жилд 6920668,3 мянган төгрөгний жижиглэн, болон бөөний худалдаа хийжээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзэхэд 5 дахин өссөн байна. Үүнээс: Хүнсний бараа гүйлгээ 12,9%-иар, согтууруулах ундааны гүйлгээ 23 дахин өсч, бараа 85,2%-иар, нийтийн хоолны гүйлгээ 43,5%-иар тус тус буурсан байна.



/мян.төг/

Үзүүлэлтүүд	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он
Нийт бараа гүйлгээ	1003660.2	782170.2	936816.2	1024043.0	6920668.3	48742800.0
Хүнсний бараа гүйлгээ	596789.9	477058.8	589097.9	724211.2	1541809.2	31088200.0
Согтууруулах ундаа	321852.2	259664.0	299100.4	212836.9	5320239.3	17048900.0
Бараа	66839.4	23014.3	27787.9	49834.5	42459.8	605700.0
1 хүнд ногдох бараа гүйлгээний хэмжээ /төгрөгөөр/	34800	26000	29800	31500	210400	1466600

Нэг хүнд ногдох бараа гүйлгээний хэмжээ 1466600 төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 7 дахин өссөн байна.




### Аж ахуйн нэгж,байгууллагын тоо (хариуцлагын хэлбэрээр)

Хариуцлагын хэлбэр	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он
ББХН	10	10	9	9	10	11
ЗБХН	8	6	5	7	7	7
ХК	3	3	3	3	3	2
ХХК	357	368	405	445	503	595
Хоршоо	8	7	7	8	13	14
Хадгаламж зээлийн хоршоо	2	2	-	-	-	-
ОНСҮГ	2	2	3	4	4	4
Сан	4	5	5	5	5	5
Төсөвт байгууллага	29	32	38	37	41	42
Шашны байгууллага	1	2	4	4	4	4
Төрийн бус байгууллага	9	11	19	29	44	77
Олон нийтийн байгууллага	35	36	36	37	44	50
Салбар	111	117	120	127	138	140
<b>БҮГД</b>	<b>579</b>	<b>601</b>	<b>654</b>	<b>715</b>	<b>816</b>	<b>951</b>

Дүүргийн татварын хэлтэст нийт 951 аж ахуйн нэгж байгууллага бүртгэлтэй байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 135-аар буюу 16,5 %иар өссөн байна.

Аж ахуйн нэгж байгууллагын тоо



## **ӨМЧ, ГАЗРЫН ХАРИЛЦАА**

Дүүргийн газрын нэгдмэл сан 68764 га байгаагаас 31,7 хувь нь ХАА-н газар, 17,2 хувь нь хот тосгон суурины газар, 1,46 хувь нь зам шугам сүлжээний газар, 2,4 хувь нь ойн сан бүхий газар, 0,01 хувь нь усны сан бүхий газар, 47,2 хувь нь улсын тусгай хэрэгцээний газар байна.

15173 өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн 14983,1 га газар байгаагаас 2003-2013 онд нийт 3236 иргэнд 173,16 га газрыг өмчлүүлсэн байна. 10 аж ахуйн нэгж, 11 иргэний газар эзэмших эрхийг хүчингүй болгосон бөгөөд газрын төлбөрөө төлөөгүй болон урьд оны өглөгтэй 360 газар эзэмшигч, ашиглагч байна.

Шинээр суурьшлын бүс бий болгохоор төлөвлөсөн 5-р хорооны Элстэйн хэсэгт нийт 19 удаагийн олголтоор 3800 иргэнд ахуйн зориулалтаар газар олгожээ.

## МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БААТРУУД



БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар Д.Чанкий



БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар Ж.Батлай



БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар А.Орногвай



БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар Ч.Пүрэв



БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар Т.Окобал



БНМАУ-ын Хөдөлмөрийн ууган баатар Д.Даваажав



БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар Х.Түвшин



БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар, Гавъяат уурхайчин Ж.Отгонцагаан



БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар Н.Залил

### ТӨРИЙН ШАГНАЛТ УУРХАЙЧИД



Ц.Дорж



Н.Луесанчоймбол



У.Маалет

**ГАВЪЯАТ УУРХАЙЧИД**



Гавъяат уурхайчин  
Д.Пүрэвз



Гавъяат уурхайчин  
Ч.Адрес



Гавъяат уурхайчин  
З.Жавлай



Гавъяат уурхайчин  
Ц.Сандаг



Гавъяат уурхайчин  
Ж.Сайполда



Гавъяат уурхайчин  
Х.Кадас



Гавъяат уурхайчин  
Ө.Шаравхаан



Гавъяат уурхайчин  
С.Банзрагч



Гавъяат уурхайчин  
Ч.Жанчив



Гавъяат уурхайчин  
С.Жадамбаа



Гавъяат уурхайчин  
Л.Дамдинсүрэн



Гавъяат уурхайчин  
Балдорж

**АРДЫН БОЛОН ГАВЪЯАТ БАГШ НАР**



Ардын уран зохиолч,  
Төрийн шагналт яруу  
найрагч Ш. Сүрэнжав



Гавъяат багш  
Х.Долгор



Гавъяат багш  
Д.Дамдинжав



Гавъяат багш  
Ж.Юра



Гавъяат багш, Уртын  
дуучин  
Ц.Дэлгэр

**ГАВЪЯАТ ЖУЖИГЧИД**



П.Нямсүрэн



Б.Туяа



Ж.Алтанцэцэг



Ч.Амаржаргал

## НАЛАЙХААС ТӨРСӨН ГАВЪЯАТ ТАМИРЧИД



Монгол Улсын Гавъяат дасгалжуулагч, чөлөөт бөхийн Ази тивийн аварга, Улсын начин Д.Адъяатөмөр



Монгол Улсын Гавъяат тамирчин, чөлөөт бөхийн Ази тивийн аварга, Олимпын наадмын 4-р байрын шагналт, Улсын гарди П.Сүхбат



Монгол Улсын Гавъяат дасгалжуулагч, чөлөөт бөхийн улсын шигшээ багийн ахлах дасгалжуулагч асан А.Цэдэнсодном



Монгол Улсын Гавъяат тамирчин, чөлөөт бөхийн Олон Улсын хэмжээний мастер М.Хойлогдорж



Монгол Улсын Соёлын Гавъяат зүтгэлтэн, Улсын начин, үндэсний бөхийн тайлбарлагч агсан А.Ганбаяатал



Монгол Улсын Гавъяат тамирчин, Японы мэргэжлийн сумогийн тамирчин Н.Цэвээням

### УЛСЫН АЛДАР ЦОЛТОЙ УЯАЧИД



Монгол Улсын тод манлай уяач Д.Гарамжав



Монгол Улсын тод манлай уяач, Монгол улсын гавъяат малчин Г.Сандуйжав



Монгол Улсын манлай уяач Н.Түмэнбаяр



Монгол Улсын алдарт уяач А.Алтангадас



Монгол Улсын алдарт уяач Т.Энхтайван



Монгол Улсын алдарт уяач Г.Ганбат



Монгол Улсын алдарт уяач, Улсын начин Г.Ганхүү

## НАЛАЙХ ДҮҮРГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО



Намын дарга  
С.Амарсайхан

Намын дэд дарга  
С.Батжаргал

1929 онд Налайхын уурхайн анхны намын үүр байгуулагдаж, даргаар нь Цахар Лувсан, 1933 онд 21 гишүүнтэй орон тооны үүр болж даргаар нь улаан цэргийн сургагч байсан Өлзийн Цэвээн гэдэг хүн сонгогдон ажиллаж байжээ. 1939 оны сүүлчээр Налайхын уурхайн Намын хороог байгуулж, бүгд хурлын гишүүн 27, тэргүүлэгч гишүүнээр 5 хүн, намын хорооны анхны даргаар Балбарыг сонгож баталсан байна. Намын хороо тухайн үедээ нүүрсний уурхайн төлөвлөгөөний биелэлтийг гартаа авч, эрчимжүүлэн уурхайчдыг намын гишүүд манлайлан ажиллаж байлаа. 1940- өөд оноос цаг үеийн шаардлага, үйлдвэрийн онцлогоос шалтгаалан намын хорооны нэр өөрчлөгдөж байсан бөгөөд 1962 онд Налайх хотын намын хороо, дараа нь Налайхын районы намын хороо, Налайх дүүргийн намын хороо гэж нэрлэгдэж ирсэн түүхтэй.

## НАЛАЙХ ДҮҮРГИЙН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО



Намын дэд дарга  
О.Ганболд

Намын дэд дарга  
Б.Батболд

Монголын Ардчилсан Холбооны салбар зөвлөлийг 1989 оны 12 дугаар сарын 17-ны өдөр С.Батболд, Б.Эрдэнэчулуун, Т.Жамбал, П.Санж нар анх үүсгэн байгуулж, Монголын Ардчилсан Холбоо-Ард түмний хөдөлгөөнд нэгдэх тухай шийдвэр гарган төлөөлөгч томилон МоАх-ны удирдлагуудтай уулзан удирдамж, чиглэл авч, орон сууцны 16 дугаар байрны 15 тоот буюу Л.Ганболд (МоАх-ны анхны гишүүдийн нэг)-ын гэрт байрлан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд МоАХ-ны Налайх дахь салбар зөвлөлийн анхны зохицуулагчаар С.Батболд 1990 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр томилогдон, 1990 оны 6 дугаар сараас С.Батсайхан ажиллах болжээ. Улмаар МҮАН, МСДН байгуулагдан үйл ажиллагаа нь өргөжиж, МоАН-ын Налайх дүүргийн хорооны даргаар С.Батсайхан, Б.Эрдэнэчулуун, И.Батмөнх, Ө.Энхбаяр нар ажиллаж байв.

2000 оны 12 дугаар сарын 06-ны өдөр ардчилалын төлөө таван нам нэгдэн Ардчилсан нам байгуулж, намын хорооны даргаар Т.Самбасанчир, дэд даргаар П.Чинбат, нарийн бичгийн даргаар Дэчинравдан нар ажиллаж байсан.

2009 оноос Ардчилсан намын хорооны даргаар Х.Болдбаатар сонгогдож, намын дэд даргаар О.Ганболд, Б.Батболд нар ажиллаж байна. 2010 оноос 2012 оны 12 дугаар сар хүртэл Хэрэг эрхлэх газрын даргаар О.Манарбек ажилласан.

Намын анхан шатны 6 үүр, Зөвлөлдөх зөвлөл, Хяналтын салбар хороо, Намын дэргэдэх эмэгтэйчүүдийн, ахмадын, залуучуудын зэрэг олон нийтийн байгууллага, 75 сонгуульт гишүүн, 1400 гаруй гишүүнтэй.

Намын хорооны даргаар ажиллаж байсан хүмүүс:

Т.Самбасанчир-2000 оны 12 дугаар сараас

Д.Батцэрэг-2003 оны 5 дугаар сараас

П.Тунгалаг-2004 оны 10 дугаар сараас

Т.Самбасанчир-2006 оны 3 дугаар сараас

П.Чинбат-2006 оны 11 дүгээр сараас

Х.Болдбаатар-2009 оны одоог хүртэл

#### **НАЛАЙХ ДҮҮРГИЙН МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМЫН ХОРОО**



Намын дарга Н.Баяраа

Дэд дарга Д.Цогоо

МАХН-ын нэрийг 2010 оны 11 дүгээр сард МАН болгон өөрчилсөн тэр үеэс л түүхэн уламжлал, үнэт зүйлээ авч үлдэхийн тулд үнэнч гишүүд дэмжигчдийнхээ хүсэл зориг, нийгмийн захиалгаар 2011 оны 1 дүгээр сарын 27, 28-нд хуралдсан “МАХН-ын Онц Их Хурал”-д дүүргээс Я.Ичваан тэргүүтэй 13 төлөөлөгч оролцсон.

Налайх дүүрэгт 2011 оны 11 дүгээр сарын 21-нд албан ёсоор Мянгатын зөвлөл байгуулагдсан бөгөөд зөвлөлийн тамгыг Я.Ичваан гардан авч шинэчлэгдсэн МАХН-ын үйл хэргийг орон нутагт хөтлөн явуулах, түгээн дэлгэрүүлэх их ажлын эхлэл тавигдаж, сарын дараа хуралдсан дүүргийн МАХН-ын Мянгатын зөвлөлийн бүх гишүүдийн хурлаар Н.Баярааг Мянгатын даргаар сонгон баталж, хороодод Зуут байгуулан улс төрийн үйл ажилагаагаа идэвхижүүлж эхэлсэн. Нийслэлийн ИТХ-ыг сонгох 2012 оны сонгуульд Намын хорооны дарга Н.Баяраа МАХН-МУАН-ын “Шудрага ёс” эвслийн нийслэлийн сонгуулийн штабын даргаар ажиллаж, тус эвслээс жагсаалтаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 4 төлөөлөгч сонгогдсон. Дүүргийн ИТХ-ыг сонгох сонгуульд МАХН нийт сонгогчдын 24.3 хувийн санал авч Д.Цогоо, Ц.Хатанбаатар нар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд төлөөлөгчөөр сонгогдон ажиллаж байна.



## **БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ТҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТ:**

2005, 2009, 2013 онуудад дүүргийн Засаг даргын захирамжаар Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоо болон дэргэдэх байгууллагуудыг дараах жагсаалтаар баталсан.

Үүнд:

**Нэг:** Дүүргийн Засаг даргын 2005 оны 37 дугаар захирамжаар:

Дэргэдэх байгууллагуудыг:

1. Газрын алба
2. Биеийн тамир, спортын хороо
3. Хөдөлмөр ,халамж үйлчилгээний хэлтэс
4. Статистикийн хэлтэс
5. Татварын хэлтэс
6. Цагдаагийн хэлтэс
7. Эрүүл мэндийн нэгдэл
8. Хангамж үйлчилгээний төв
9. Цэцэрлэгжүүлэлтийн алба
10. Тохижилт үйлчилгээний компани
11. Гамшгаас хамгаалах штаб
12. Замын цагдаагийн тасаг
13. Гэгээрэл, хүүхэд, хөгжлий төв

Засаг даргын Тамгын газрын бүтцийг:

1. Төрийн захиргааны хэлтэс
2. Санхүү, эдийн засаг, төрийн сангийн хэлтэс
3. Нийгмийн хөгжлийн хэлтэс
4. Үйлдвэрлэл, тохижилт, үйлчилгээний хэлтэс
5. Цэргийн штаб
6. Аж ахуйн тасаг

**Хоёр:** Дүүргийн Засаг даргын 2009 оны 25 дугаар захирамжаар:

Дэргэдэх байгууллагуудыг:

1. Боловсролын хэлтэс /Албан бус боловсролын төв/
2. Биеийн тамир, спортын хороо
3. Мэргэжлийн хяналтын хэлтэс
4. Нийгмийн даатгалын хэлтэс
5. Халамжийн үйлчилгээний хэлтэс
6. Онцгой байдлын хэлтэс
7. Статистикийн хэлтэс
8. Соёл, урлагийн ордон

9. Татварын хэлтэс
10. Газрын алба
11. Хөдөлмөрийн хэлтэс
12. Хүүхэд хөгжлийн төв
13. Цагдаагийн хэлтэс /Замын цагдаагийн тасаг/
14. Эрүүл мэндийн нэгдэл

Засаг даргын Тамгын газрын бүтцийг:

1. Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /олон нийт мэдээлэл харилцааны тасаг, бүртгэл мэдээллийн тасаг, аж ахуйн тасаг/
2. Санхүү, төрийн сангийн хэлтэс
3. Нийгмийн хэлтэс
4. Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс
5. Цэргийн штаб

**Гурав:** Дүүргийн Засаг даргын 2013 оны Б/14 дүгээр захирамжаар:

Дэргэдэх байгууллагуудыг

1. Ахмадын хороо
2. Албан бус боловсролын төв
3. Боловсролын хэлтэс
4. Бүртгэлийн хэлтэс
5. Биеийн тамир, спортын хороо
6. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв
7. Мэргэжлийн хяналтын хэлтэс
8. Нийгмийн даатгалын хэлтэс
9. Нийгмийн халамжийн үйлчилгээний хэлтэс
10. Онцгой байдлын хэлтэс
11. Өмч, газрын харилцааны алба
12. Статистикийн хэлтэс
13. Соёл, урлагийн ордон
14. Татварын хэлтэс
15. Хөдөлмөрийн хэлтэс
16. Худалдан авах ажиллагааны алба
17. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төв
18. Цагдаагийн хэлтэс (Замын цагдаагийн тасаг)
19. Эрүүл мэндийн нэгдэл
20. Хангамж үйлчилгээний төв
21. Гэрэлтүүлэг, чимэглэлийн алба

22. Цэцэрлэгжүүлэлтийн алба

23. “Тохжилт үйлчилгээ” НӨҮГ

Засаг даргын Тамгын газрын бүтцийг:

1. Захиргаа, хуулийн хэлтэс
2. Санхүү, төрийн сангийн хэлтэс
3. Нийгмийн хөгжлийн хэлтэс
4. Тохжилт, худалдаа үйлчилгээний хэлтэс
5. Цэргийн штаб гэсэн бүтэцтэй байхаар баталсан.

## ХӨМРӨГИЙН ТҮҮХ

Нийслэлийн Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар нь анх 1988 оны 02 дугаар сараас архивын баримтын хөмрөг үүсгэсэн түүхтэй. Тус хөмрөг нь 1960-1982 оны баримтыг Улсын түүхийн төв архивт гэрээгээр гүйцэтгүүлсэн байдаг.

1960-1982 оны баримт нь 634 хадгаламжийн нэгжтэй байсан бөгөөд түүвэр устгал хийж 114 хадгаламжийн нэгж устгасан байна. Эдгээр хөмрөгийн баримтын данс нь гурван тусдаа бүртгэлтэй байсан ба дахин боловсруулалт хийж гурван бүртгэлийг нэгтгэж 1960-1996 оны 619 хадгаламжийн нэгжтэй данс болгосон.

Дахин боловсруулалт хийх явцад устгасан баримт гараагүй байна.

Тус хөмрөгийн баримтууд нь Нийслэлийн Архивын хадгаламжийн 41-р сангийн данс 1-д хадгалагдаж байдаг. Үүнд:

Налайх хотын АДХГЗ-ны захирамж, сонгуулийн чуулганы материал, АДХГЗ-ны гишүүдийн хуралдааны тогтоол, протокол, Мал тооллогын материал, хэлтсүүдийн жилийн ажлын тайлан, төлөвлөгөө, Уурхайчдын хорооны гүйцэтгэх захиргааны даргын захирамж, сургуулийн багш нарын холбогдолтой статистик мэдээ, Улсын хөрөнгө оруулалтаар авсан хөрөнгийн тооцоо, Захиргааны зарлагын төсөв, Төсөвт зардлын гүйцэтгэлийн тайлан баланс, Захиргаа үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн хорооны хурлын тогтоол, албан даалгавар, Түүхий эдийн бэлтгэл, мах ноосны оногдлын төлөвлөгөө, тайлан, аж ахуйн салбарт ажиллагсадын судалгаа, жилийн эцсийн тайлан баланс хадгалагдаж байдаг.

2013 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн Нийслэлийн Архивын газрын ББНШАЗК-ын хурлаар Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын архивын хадгаламжийн 41 дүгээр сангийн данс 2-д 1997-2010 оны баримтын дансыг батлуулж нөхөн бүрдүүлэлтээр хүлээлгэн өгсөн байдаг.

Энэхүү хурлаар байнга хадгалах 1997-2010 оны 400 ХН, 2000-2010 оны түр хадгалах 1141 ХН, 1971-2010 оны 70 жил хадгалах 145 ХН, 1990-2010 оны хадгалах хугацаа дууссан, түүх эрдэм шинжилгээний болон практик ач холбогдолгүй болсон утсгах хэргийн 641 ХН-ийн данс, бүртгэл, жагсаалтыг тус тус батлуулж данс бүртгэлийн дагуу нийслэлийн Архивын газарт байнгын баримтыг шилжүүлсэн. Үүнд:

Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газарт дээд газраас ирсэн тогтоол шийдвэрийн биелэлтүүд, дүүргийн Засаг даргын захирамжууд, Тамгын газрын дарын тушаалууд, Нийслэл дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн биелэлтүүд, Нийслэл, дүүргийн нийгэм эдийн засгийн зорилтын хэрэгжилтүүд, дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлүүд, дүүргийн Засаг даргын батламжийн биелэлтүүд, Улаанбаатар хотын захирагч бөгөөд нийслэлийн Засаг дарга, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, дүүргийн Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээ, гэрээний биелэлтүүд, Засаг даргын Тамгын газрын болон

хэлтсүүдийн жилийн ажлын төлөвлөгөө, тайлангууд, Тамгын газрын жилийн эцсийн санхүүгийн тайлан балансууд, санхүүгийн тайланд хийсэн шалгалтын дүн мэдээ, дүүрэгт орон нутаг, нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын тендэрийн баримт бичгүүд, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлүүд, дүүргийн Засаг даргын Тамгын газарт үндсэн үйл ажиллагаатай холбоотой ирсэн, Тамгын газраас явуулсан бичгүүд, жил жилийн зорилтын хүрээнд хийсэн ажлын тайлангууд, дүүрэгт хэрэгжүүлсэн тогтвортой амьжиргаа төслөөр хэрэгжсэн төслүүд, холбогдох баримт бичгүүд зэрэг баримтууд байсан.

Мөн устгах хэргийн актын баримтын жагсаалтын дагуу нийт 641 ХН-ийг Засаг даргын Тамгын газрын ББНШК-ын хурлын комиссын гишүүдийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан 2014 оны 1 дүгээр сард устгалыг хийсэн.

Одоогоор дүүргийн Засаг даргын Тамгын газрын архивт 2011-2013 оны байнгын 242 ХН, 2000-2013 оны түр хадгалах 1495 ХН, 1971-2013 оны 70 жил хадгалах 225 ХН, 2011-2013 оны тусгай төрлийн 13 ХН-үүд тус тус хадгалагдаж байна.

Мөн Ахуйн үйлчилгээний комбинатын 1977-1991 оны байнга хадгалах 36 ХН, 1987-1991 оны 70 жил хадгалах 36 ХН, 1994-1999 оны Хүнс барааны захын байнга хадгалах 25 ХН, цэцэрлэг сургуулийн хангамжийн байнга болон түр хадгалах 12 ХН, Барилга угсралтын конторын байнгын хадгалах 48 ХН, Налайхын их уурхай байнга хадгалах 68 ХН 70 жил хадгалах хадагалах 248 ХН, Уурхайн барилга трестийн байнга хадгалах 89 ХН болон 70 жил хадгалах 62 ХН тус тус хадгалагдаж байна.

Мөн тус архивт 2009, 2011 онуудад архивын баримтын тооллогыг явуулсан байдаг ба 2011 оны байдлаар нийт цаасан суурьтай баримт 1877 ХН, тусгай төрлийн баримт 26, бусад төрлийн баримт 3 ХН байсан байна.

## **ХӨМРӨГИЙН БАРИМТЫН ТОДОРХОЙЛОЛТ**

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын архивт 2011-2013 он байнга хадгалах 225 ХН, 70-н жил хадгалах 1971-2013 оны 225 ХН түр хадгалах 2000-2013 оны 1495 ХН, дүүргийн татан буугдсан Ахуйн үйлчилгээний компинатны 70-н жил хадгалах 1978-1991 оны 36 ХН, байнга хадгалах 36 ХН, Барилга угсралтын конторын 1963-1998 оны байнга хадгалах 38 ХН, Налайхын их уурхайн 1958-1995 оны байнга 68 ХН, 70 жил хадгалах 248 ХН, Уурхайн барилга трестийн 1976-2000 оны байнга 89 ХН, 70 жил хадгалагдах 62 ХН нийт 2922ХН тус тус хадгалагдаж байна.

Тус Засаг даргын Тамгын газрын архивын баримтын хөмрөгт байгаа байнга хадгалах 225 ХН-ийн дансанд дүүргийн Засаг даргын захирамжууд, Тамгын газрын даргын тушаалууд, байгууллагын болон хэлтсүүдийн жилийн ажлын төлөвлөгөө тайлангууд, Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлүүд, дээд газрын тогтоол шийдвэрүүдийн биелэлт, тухайн жилийн эдийн засаг, нийгмийн зорилтын биелэлтүүд, харьяа хэлтэс, газруудад зохион байгуулсан үзлэг шалгалтын ажлын илтгэх хуудас баримтууд, төсөвт байгууллагуудын гэрээ, гэрээний биелэлтүүд, дүүрэгт хийгдсэн хөрөнгө оруулалттай холбогдолтой тендэрт шалгаран хийсэн ажлуудын баримтууд, Засаг даргын батламжийн биелэлтүүд, дүүргийн болон Тамгын газрын жилийн эцсийн санхүүгийн тайлангууд, орлого зарлагын гүйцэтгэлийн мэдээнүүд зэрэг баримт бичгүүд орсон байна.

Түр хадгалах 1495 ХН-ийн бүртгэлд дээд газраас ирсэн тогтоол шийдвэрүүд, хэлтэс, тасаг, хороодын ажилтнуудын бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээ, гэрээний биелэлтүүд, төсөвт газруудын улирлын тайлан баланс, харьяа аж ахуйн нэгж байгууллагуудын улирал, жилийн ажлын тайлан баланс, санхүүгийн баримтууд, өдөр тутмын гүйлгээнүүд, кассын баримтууд, төсөвт байгууллагуудын санхүүжилтийн захиалга, мэдээ, төсвийн орлогын мэдээ, төрийн албан хаагчдийн нэг хүүхдийн сургалтын төлбөртэй холбогдсон гэрээнүүд, ирсэн явсан бичгүүд болон өргөдөл гомдлын бүртгэлүүд, тохижилтын ажлын тайлангууд, хороодын ажлын тайлан мэдээнүүд, жолоочийн тооцооны хуудас, нийтийн тээврийн бүртгэлүүд, захирамжийн төсөл, зөвшөөрөл авсан баримтууд, ирсэн, явсан бичгийн бүртгэлийн дэвтрүүд зэрэг баримт бичгүүд байна.

70-н жил хадгалах 214 ХН-ийн бүртгэлд дүүргийн Засаг даргын “Б” захирамж болон Тамгын газрын даргын Б тушаалууд, орон сууцны гэрчилгээ олгосон баримтууд, цалингийн картууд, шагналд тодорхойлсон болон шагнагдсан иргэдийг материалууд, асран хамгаалагч харгалзан дэмжигчээр тогтоосон хувийн хэргүүд хадгалагдаж байна.

Тусгай төрлийн баримтанд гэрэл зураг болон дүрс бичлэгийн нийт 13 ХН байгаа ба 2012-2013 оны үндсэн үйл ажиллагааны холбогдолтой баримтууд CD-гээр хадгалагдаж байна.

Татан буугдсан Ахуйн үйлчилгээний компинатны 70-н жилийн болон байнга хадгалах 1978-1991 оны ажилчдын цалингийн картууд, хүнс барааны захын даргын тушаалууд, хуучнаар Барилга угсралтын конторын даргын 1975-1995 оны тушаалууд, Налайхын их уурхайн байнга болон 70 жил хадгалах 1958-1995 оны даргын тушаалууд, ажилчдын цалингийн карт, цалингийн цэс, цалингийн хүснэгтүүд, Уурхайн барилга трестийн байнга болон 70 жил хадгалах 1979-1995 оны даргын тушаалууд, ажилчдын цалингийн карт, цалингийн цэс, цалингийн хүснэгтүүд зэрэг нийт 1326 ХН тус тус хадгалагдаж байна.

Архивын лавлагаа, мэдээлэл олгох журам, Засаг даргын 2009 оны 05 дугаар сарын 8-ны өдрийн 165 дугаар захирамж (Үйлчилгээний орлогын тухай)-ийг мөрдлөг болгон 2014 оны 09 дүгээр сарын байдлаар байгууллага, иргэдэд 148 лавлагаа олгож үйлчилгээ үзүүлжээ.

Мөн 2014 оны эхний 9 сарын байдлаар Архиваас Засаг даргын Тамгын газрын ажилтан, албан хаагчдад 92 хадгаламжийн нэгжийг түр хугацаагаар ашиглуулсан байна. 2014 онд архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулан өрөөг өргөтгөн томсгосон, ашиглалтын, хэвийн нөхцөл байдлыг хангах сайжруулах үүднээс чийгшүүлэгч шинээр байрлуулан архивын өрөөний чийг, дулааны хэмжилт, цэвэрлэгээ үйлчилгээг 7 хоног бүр хийлгэн тогтмол тэмдэглэл хөтлөн ажиллаж байна.

Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Түүхчилсэн лавлахыг 2006 онд Д.Оюунбилэг, З.Саранхүү, 2009 онд С.Мөнгөнчимэг, 2012 онд Т.Наранцэцэг нар бичиж тухай бүрт нь баяжилт хийж ирсэн байна.

Засаг даргын Тамгын газрын даргын 2014 оны А/92 дугаар тушаалаар байгууллагын 2014 оны түүхчилсэн лавлахыг бичих ажлын хэсгийг байгуулан, ажлын хэсгийн ахлагчаар Захиргаа, хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн М.Мөнхбаяр, гишүүдэд мэргэжилтэн Б.Хүслэн, Б.Ариунхүслэн, Т.Наранцэцэг, ахмад ажилтан Р.Буяндэлгэр нар ажиллан түүхчилсэн лавлахыг бичиж, Захиргаа хуулийн, хэлтсийн дарга Л.Болормаа редакторласан.

--00--